

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан Хэнтий сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/082/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 372

танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ХАН ХЭНТИЙ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ К.ТҮМЭНДЭЛГЭР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан Хэнтий сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,289,591.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 26,012.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 404,212.8 мянган төгрөг нийт 2,719,816.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн гүйцэтгэлээр 2,946,851.8 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 70,919.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, 43,624.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 187,778.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10,672.2 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 2,835.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй тайлагнасан, 174,270.4 мянган төгрөгийн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 92.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	555,221,353.02	338,799,217.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	270,660,536.55	43,624,728.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	270,660,536.55	43,624,728.99
3121	Төгрөг	270,660,536.55	43,624,728.99
31211	Төрийн сангийн харилцах	270,660,536.55	43,624,728.99
33	АВЛАГА	9,500,000.00	844,989.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	844,989.00
335	Бусад авлага	9,500,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	9,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	275,060,816.47	294,329,499.64
351	Түүхий эд материал	5,258,385.00	3,937,965.00
35110	Тусгай зориулалттай материал	3,427,515.00	2,014,915.00
35130	Эм боох материал	1,830,870.00	1,923,050.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,634,690.00	2,320,650.00
354	Хангамжийн материал	262,167,741.47	288,070,884.64
35410	Бичиг хэргийн материал	54,457,089.39	69,015,492.56
35420	Аж ахуйн материал	13,217,500.00	13,644,800.00
35460	Хүнсний материал	4,856,100.00	4,116,470.00
35470	Бусад хангамжийн материал	189,637,052.08	201,294,122.08
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,390,280,852.58	5,229,654,943.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,390,280,852.58	5,229,654,943.22
392	Биет хөрөнгө	2,870,948,852.58	4,709,772,943.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,698,914,609.76	4,735,578,868.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(339,295,664.72)	(440,482,708.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	585,408,066.48	545,391,861.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(255,078,341.17)	(296,766,563.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	163,932,252.95	158,482,220.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(74,697,995.54)	(67,466,184.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	135,521,255.67	97,460,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(43,755,330.85)	(22,425,250.05)
393	Биет бус хөрөнгө	519,332,000.00	519,882,000.00
39301	Програм хангамж	1,237,798.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,237,798.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	519,332,000.00	519,332,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,945,502,205.60	5,568,454,160.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	133,409,960.34	77,962,013.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	133,409,960.34	77,962,013.00
413	Өглөг	133,409,960.34	77,962,013.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	518,298.34	-
4136	Бусад өглөг	132,891,662.00	77,962,013.00
41361	Байгууллагад төлөх өглөг	132,891,662.00	77,962,013.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,812,092,245.26	5,490,492,147.85
51	Засгийн газрын хувь оролцоо	3,812,092,245.26	5,490,492,147.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	990,622,936.62	990,622,936.62
51101	Өмч: - төрийн	990,622,936.62	990,622,936.62
512	Хуримтлагдсан үр дүн	1,589,402,223.80	3,267,802,126.39
51210	Өмнөх үеийн үр дүн	1,589,402,223.80	1,589,402,223.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,678,399,902.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,232,067,084.84	1,232,067,084.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,945,502,205.60	5,568,454,160.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,036,795,235.42	4,827,638,962.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	618,166,735.42	2,133,834,962.89
120	Нийтлэг татварын бус орлого	618,166,735.42	2,133,834,962.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,121,544.00	16,512,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,921,544.00	16,512,000.00
120017	Үнэ төлбөргүй орлого- Үндсэн хөрөнгө	559,136,857.02	2,092,527,256.89
120018	Үнэ төлбөргүй орлого- Бараа материал	39,908,334.40	24,795,706.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,418,628,500.00	2,693,804,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,077,412,000.00	2,289,591,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,077,412,000.00	2,289,591,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,216,500.00	404,212,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,216,500.00	404,212,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,596,972,747.33	3,149,239,060.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,596,972,747.33	3,149,239,060.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,512,193,889.49	2,934,717,640.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,567,337,017.80	1,924,323,571.63
210101	Үндсэн цалин	1,039,921,196.72	1,190,835,106.30
210102	Нэмэгдэл	456,486,415.55	575,012,687.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	59,828,995.43
210104	Урамшуулал	70,929,405.53	98,646,782.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,919,222.16	230,613,895.17
210201	Тэтгэврийн даатгал	134,815,397.38	158,882,688.73
210202	Тэтгэмжийн даатгал	15,787,032.50	19,256,983.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,050,339.52	9,639,936.13
210204	Ажилгүйдлийн даатгал	7,304,779.42	10,023,497.78
210205	Эрүүл мэндийн даатгал	28,961,673.34	32,810,789.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,851,172.16	323,293,032.29
210301	Гэрэл, цахилгаан	23,587,094.16	33,361,517.31
210302	Түлш, халаалт	241,806,312.00	245,922,059.00
210303	Цэвэр, бохир ус	43,457,766.00	44,009,455.98
2104	Хангамж, бараа материалын зардал	81,521,727.82	11,692,772.83
210401	Бичиг хэрэг	26,150,750.00	10,000.00
210404	Ном, хэвлэл	7,481,421.42	2,014,132.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,076,556.40	9,668,640.00
210408	Бараа материал акталсны зардал	813,000.00	-
2105	Нормативт зардал	30,645,950.00	68,907,030.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,694,330.00	233,920.00
210502	Хоол, хүнс	26,951,620.00	68,673,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,633,238.00	11,215,230.00
210604	Урсгал засвар	30,633,238.00	11,215,230.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,306,755.82	33,862,642.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,275,200.00	750,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,031,555.82	33,112,442.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,978,805.73	330,809,466.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,129,800.00	48,949,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,889,600.00	11,954,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	219,959,405.73	269,905,166.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,778,857.84	214,521,419.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,413,530.00	143,601,652.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	84,323,530.00	126,216,152.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,000.00	17,385,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	365,327.84	70,919,767.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	365,327.84	70,919,767.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	439,822,488.09	1,678,399,902.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	439,822,488.09	1,678,399,902.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,437,750,044.00	2,719,816,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,121,544.00	26,012,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,121,544.00	26,012,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,121,544.00	16,512,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,921,544.00	16,512,000.00
120009	Бусад орлого	-	9,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,418,628,500.00	2,693,804,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,077,412,000.00	2,289,591,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,077,412,000.00	2,289,591,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,216,500.00	404,212,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,216,500.00	404,212,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,392,160,087.72	2,930,099,807.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,392,160,087.72	2,930,099,807.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,305,219,189.88	2,719,058,777.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,566,748,207.64	1,925,290,345.27
210101	Үндсэн цалин	1,039,332,386.56	1,191,423,983.04
210102	Нэмэгдэл	456,486,415.55	575,390,584.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	59,828,995.43
210104	Урамшуулал	70,929,405.53	98,646,782.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,919,222.26	231,010,408.87
210201	Тэтгэврийн даатгал	134,815,397.38	159,279,202.43
210202	Тэтгэмжийн даатгал	15,787,032.59	19,256,983.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,050,339.52	9,639,936.13
210204	Ажилгүйдлийн даатгал	7,304,779.42	10,023,497.78
210205	Эрүүл мэндийн даатгал	28,961,673.35	32,810,789.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,851,172.16	323,293,032.29
210301	Гэрэл, цахилгаан	23,587,094.16	33,361,517.31
210302	Түлш, халаалт	241,806,312.00	245,922,059.00
210303	Цэвэр, бохир ус	43,457,766.00	44,009,455.98
2105	Нормативт зардал	31,383,720.00	65,726,030.00
210502	Хоол, хүнс	31,383,720.00	65,726,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	32,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,527,355.82	37,154,000.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,762,900.00	702,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,764,455.82	36,451,900.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,789,512.00	126,584,961.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,473,312.00	114,403,761.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,316,200.00	12,181,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,940,897.84	211,041,029.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,575,570.00	140,121,262.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,475,570.00	122,735,762.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	17,385,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	365,327.84	70,919,767.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	365,327.84	70,919,767.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	45,589,956.28	(210,283,807.56)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	16,752,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,752,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,752,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	16,752,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(16,752,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	45,589,956.28	(227,035,807.56)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	270,660,536.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	270,660,536.55	43,624,728.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	1,149,579,735.71		3,372,269,757.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	1,149,579,735.71	-	3,372,269,757.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	439,822,488.09		439,822,488.09
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	1,589,402,223.80	-	3,812,092,245.26
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	1,589,402,223.80	-	3,812,092,245.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	1,589,402,223.80	-	3,812,092,245.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,678,399,902.59		1,678,399,902.59
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	3,267,802,126.39	-	5,490,492,147.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,017,568,200.00	2,875,932,039.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,017,568,200.00	2,875,932,039.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,871,787,700.00	2,735,810,777.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,963,228,600.00	1,925,290,345.27
210101	Үндсэн цалин	1,287,393,900.00	1,191,423,983.04
210102	Нэмэгдэл	603,025,200.00	575,390,584.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	59,828,995.43
210104	Урамшуулал	72,809,500.00	98,646,782.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,403,700.00	231,010,408.87
210201	Тэтгэврийн даатгал	166,874,400.00	159,279,202.43
210202	Тэтгэмжийн даатгал	19,632,300.00	19,256,983.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,816,200.00	9,639,936.13
210204	Ажилгүйдлийн даатгал	9,816,200.00	10,023,497.78
210205	Эрүүл мэндийн даатгал	39,264,600.00	32,810,789.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	394,212,800.00	323,293,032.29
210301	Гэрэл, цахилгаан	58,373,700.00	33,361,517.31
210302	Түлш, халаалт	243,479,100.00	245,922,059.00
210303	Цэвэр, бохир ус	92,360,000.00	44,009,455.98
2105	Нормативт зардал	68,845,000.00	65,726,030.00
210502	Хоол, хүнс	68,845,000.00	65,726,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,795,800.00	37,154,000.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	702,100.00	702,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,093,700.00	36,451,900.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,301,800.00	143,336,961.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,120,600.00	131,155,761.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,181,200.00	12,181,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,780,500.00	140,121,262.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,780,500.00	140,121,262.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	128,395,000.00	122,735,762.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,385,500.00	17,385,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,017,568,200.00	2,648,896,232.29
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,613,355,400.00	2,289,591,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,613,355,400.00	2,289,591,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	404,212,800.00	333,293,032.29
132001	Орон нутгийн төсвөөс	404,212,800.00	333,293,032.29
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	26,012,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	26,012,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		270,660,536.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		43,624,728.99

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 10,672.2 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Цалингаас суутгасан татварыг 845.0 мянган төгрөгөөр зардалд хаасныг авлагаар бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан, дэлгэрэнгүй тайлангаарх хуримтлагдсан элэгдлийн дүн, тайлант оны элэгдлийн зардлыг 10,672.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.

Аудитаар илэрсэн нийт 187,106.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

1. Жирэмсэн, амаржсан, хүүхдээ асарч байгаа эхчүүд, тэтгэвэр тогтоолгон ажиллагч, гэрээт ажилтнуудын даатгуулагчийн төрлийн кодыг хүний нөөцийн болон НДШ-ийн программд буруу оруулснаас даатгуулагч, ажил олгогчийн төлөх шимтгэлийг 1,017.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, 1,818.4 мянган төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэснийг зөрчсөнийг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

2. Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 48.1 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 12.1 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 113.1 сая төгрөгийн 8 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Санхүүгийн аудитын асуудлаар илрүүлсэн 2,835.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингаас суутгасан татвар илүү төлсөн.	1	845.0	1	845.0			1	845.0				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй бүртгэсэн.	1	9,827.2			1	9,827.2	1	9,827.2				
Дүн	1	10,672.2	1	845.0	1	9,827.2	2	10,672.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДШ-ийг зөрүүтэй тооцсон.	1	2,835.8			1	2,835.8						
Дүн	1	2,835.8	-	-	1	2,835.8	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Мэдээллийг дутуу мэдээлсэн.	1	174,106.2			1	174,106.2						
Дүн	1	174,106.2	-	-	1	174,106.2	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Байхгүй												
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	174,106.2	-	-	1	174,106.2	-	-	-	-	-	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 209-А2370448

Чингис хот

ХЭА-2026/082/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан Хэнтий сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жирэмсэн, амаржсан, хүүхдээ асарч байгаа эхчүүд, тэтгэвэр тогтоолгосон ажиллагч, гэрээт ажилтнуудын даатгуулагчийн төрлийн кодыг хүний нөөцийн болон НДШ-ийн программд буруу оруулснаас даатгуулагч, ажил олгогчийн төлөх шимтгэлийг 1,017,396.00 (нэг сая арван долоон мянга гурван зуун ерэн зургаа) төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, 1,818,446.00 (нэг сая найман зуун арван найман мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг нягтлан бодогч Д.Эрдэнэтуяад даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 141-А2370448

Чингис хот

ХЭА-2026/082/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан Хэнтий сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 48,098,000.00 (дөчин найман сая ерэн найман мянга) төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 13,093,750.00 (арван гурван сая ерэн гурван мянга долоон зуун тавь) төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 113,078,621.00 (нэг зуун арван гурван сая далан найман мянга зургаан зуун хорин нэг) төгрөгийн 8 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг ил тод мэдээлдэггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал К.Түмэндэлгэр, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА